



## ЦУС СЭЛБЭЛТ СУДАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/ОБ

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/97 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр зөвлөх профессорын багийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ахлагч: Ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр

Нарийн бичиг: Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга  
Т.Алимаа

Гишүүд: Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын  
ажиллагааны албаны дарга Б.Цогбадрах  
Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч  
М.Цэрэндэжид  
Технологийн тасгийн эрхлэгч Н.Халиун  
Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч  
Ч.Тунгалаг  
Мэдээллийн технологи, инженер техникийн  
тасгийн эрхлэгч Ч.Далайцэрэн

2. Профессорын багийн ажиллах чиг үүргийг хавсралтаар баталсугай.
3. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг багийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Н.ЭРДЭНЭБАЯР



Tushaal.2017.doc

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2017 оны 02 сарын 22-ны өдрийн  
4/08 тоот тушаалын хавсралт

**Цус сэлбэлт судлалын чиглэлээр ажиллах  
Профессорын багийн чиг үүрэг**

- Улсын хэмжээнд цусны донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх
- Цусны донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн чиглэлээр лавлагаа тусламж үзүүлэх
- Оношилгоо, эмчилгээний заавар, стандарт, арга зүйн зөвлөмж боловсруулах
- Цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, судалгаа шинжилгээний ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах
- Цусны аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодлого, хэрэгжүүлэх стратеги зорилтыг тодорхойлох мэргэжлийн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах
- Цус сэлбэлт судлалын мэргэжлийн чиглэл, хандлагыг тодорхойлох
- Шинэ техник технологи нэвтрүүлэх, арга аргачлал батлах
- Судалгаа шинжилгээний төсөл хэлэлцэх, хэрэгжилтийн явцын үнэлгээ өгөх

Зэрэг чиг үүргийг хүлээнэ.